



2026-2027

МИЦУБИШИ АЗИЙН ХҮҮХДИЙН ЭНИККИ ФЕСТИВАЛЬ

“ЭНИККИ” зурагт өдрийн тэмдэглэлээ ирүүлж, уралдаанд оролцоорой!

**Өдөр тутмын амьдралаа Азийн бусад орны хүүхдүүдтэй хуваалцаарай.
Зурагт өдрийн тэмдэглэлээр өөрийгөө илэрхийлээрэй!**


Энэхүү арга хэмжээ нь дэлхийн хүүхдүүдэд зурагт өдрийн тэмдэглэлээр дамжуулан
Азийн хүмүүсийн өдөр тутмын амьдралтай танилцаж, тэднийг илүү сайн ойлгох
боломж олгох зорилготой.

Бид Азийн 24 улс болон бүс нутгийн хүүхдүүдийг “Энэ бол миний амьдрал” сэдвээр
зурагт өдрийн тэмдэглэлээ бүтээн ирүүлэхийг урьж байна.

Та ч бас гурван хуудас зурагт өдрийн тэмдэглэлээрээ өөрийн амьдрал, соёлыг Азийн
найзууддаа танилцуулж, энэхүү арга хэмжээнд оролцоорой!

Оролцогчдод тавих шаардлага

Бүтээл	Оролцогчийн бүтээл гурван (3) хуудас байна. Хуудас бүрд өдөр тутмын амьдралд тохиолдсон үйл явдлыг дүрсэлсэн зураг болон түүний тухай богино эссэ багтаана. Зургийн цаасан дээр усан будаг, өнгийн харандаа болон бусад зургийн хэрэгсэл ашиглан зурж болно.
Хэлбэр, хэмжээ	A4 хэмжээтэй (үрт 297 мм x өргөн 210 мм) цаасны дээд хэсгийн гуравны хоёрт зураг зурж, доод хэсгийн гуравны нэгт эссэгээ бичнэ. Зураг болон эссэг цаасны зөвхөн нүүрэн талд байрлуулж, ар талыг ашиглахгүй.
Насны ангилал	Бүтээлээ ирүүлэх үедээ 6–12 настай хүүхдүүд оролцоно.
Сэдэв	“Энэ бол миний амьдрал.” Гэр бүл, найз нөхөд, сургуулийн амьдрал, ёс заншил, баяр наадам, хот суурин, хүмүүс зэрэг өдөр тутмын амьдралынхаа аль ч талыг дүрсэлэн харуулж болно.
Хүлээн авах хугацаа	2026 оны 7 дугаар сарын 1-ээс 11 дүгээр сарын 30-ныг дуустал



Шалгаруулалтын дүнг мэдээлэх

Шагнал хүртсэн оролцогчдын нэрсийг 2027 оны 5 дугаар сард зарлана.

Шагналууд

Гран-при шагнал — 1 ялагч *Шагналын хүрээнд Гран-при шагналын эзнийг Япон Улсад зохион байгуулах шагнал гардуулах ёслол болон соёлын солилцооны хөтөлбөрт урьж оролцуулна.
Мицубишигийн Олон нийттэй харилцах хорооны шагнал — 1 ялагч
Ази, Номхон далайн бүсийн ЮНЕСКО-гийн клуб, нийгэмлэгүүдийн холбооны шагнал — 1 ялагч
ЮНЕСКО-гийн нийгэмлэгүүдийн Японы үндэсний холбооны шагнал — 1 ялагч
*Оролцогчдод хүргэн зөвлөмжийг www.enikkimongolia.mn/urilga холбоосоор орж татаж авна үү.
(Гэр, сургуулийн хаяг, холбогдох утас, нас хүйс зэргийг үнэн зөв бичиж ирүүлнэ.)
*Бүрэн гүйцэд бэлтгэсэн бүтээлээ Бүртгэлийн маягтын хамт дугтуйлж доорх хаягаар илгээнэ үү!
Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Ривер Вилла 8/1, 57 тоот
Хүлээн авагч: Байгаль, соёлын өвийг хамгаалах сан; Утас: 99122722, 80988094



Оролцогч улс орнууд: Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Бутаны Хаант Улс, Бруней Даруссалам Улс, Камбожийн Вант Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Индонез Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Малайз Улс, Мальдивын Бүгд Найрамдах Улс, Монгол Улс, Бүгд Найрамдах Мьянмарын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улс, Исламын Бүгд Найрамдах Пакистан Улс, Бүгд Найрамдах Филиппин Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Ардчилсан Социалист Бүгд Найрамдах Шри Ланка Улс, Хятадын Тайпей - Тайван Улс, Тайландын Хаант Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Тимор Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Япон Улс.

Зохион байгуулагчид: Мицубишигийн Олон нийттэй Харилцах Хороо / Ази-Номхон далайн бүсийн ЮНЕСКО-ийн Клуб, Нийгэмлэгүүдийн Холбоо / ЮНЕСКО-гийн Нийгэмлэгүүдийн Японы Үндэсний Холбоо

Үндэсний хэмжээнд зохион байгуулагч: ЮНЕСКО-ийн Батламжит ТББ - Байгаль, соёлын өвийг хамгаалах сан.

Дэмжлэг үзүүлсэн: ЮНЕСКО-ийн Клуб, Нийгэмлэгүүдийн Японы Үндэсний Холбоо болон бусад нэр дүрдсэн байгууллагын дэмжлэгтэйгээр энэхүү наадмыг зохион байгуулж байна.

Мицубиши компани “Мицубиши Азийн Хүүхдийн Эникки Фестиваль”-ийг ивээн тэтгэж байна.